



САНГИЙН ЯАМ

УЛСЫН ӨР БА ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

(Нээлттэй хэлэлцүүлэг)

Улаанбаатар хот
2015 он

АГУУЛГА

1. Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин
2. Улсын нийт гадаад өр болон Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал
3. Дунд хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрийн удирдлагын бодлого, зохицуулалт

1. Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин

Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин

1. Өрийн удирдлагын тухай хууль

- **Өрийн удирдлагын тухай** хууль 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан.
- Хуулийг дагалдан 10 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. (өмнө нь салангид байдлаар туссан зохицуулалтуудыг нэгдмэл, цогц болгосон)
- Хуульд туссан шинэлэг зохицуулалтууд:
 - Өрийн бүтэц, тооцоолол,
 - Шинэ нэр томъёонууд,
 - Тухайн төсвийн жилд хийх зээллэг, гаргах өрийн баталгааны дээд хэмжээ,
 - Өр үүсгэх зориулалт,
 - Засгийн газрын өрийн баталгаа,
 - Гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээл,
 - Орон нутгийн өрийн удирдлага.

Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин

2. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, **өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг** шинэчлэн тогтоосон (2015 - 58.3 хувь, 2016 - 55.0 хувь, 2017 - 50.0 хувь, 2018 оноос 40.0 хувь)
- Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаар “**Засгийн газрын өр**”-ийн тухай **шинэ тодорхойлолтыг** ашиглаж эхэлсэн (ТӨ ба ОНӨ хуулийн этгээдийн өрийг оруулахгүй байх)

Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин

3. Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг

- **Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг** Улсын Их Хурлын 2015 оны 51 дүгээр тогтоолоор батлуулсан.
- Стратегийн баримт бичигт туссан бодлогын зорилтууд:
 - Засгийн газрын өрийн үйлчилгээний **төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх**, өрийн багцын эргэн төлөлтийн **дундаж хугацааг уртасгах**,
 - Монгол Улсын **зээлжих зэрэглэл, төлвийг сайжруулах**, хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлэх, Засгийн газрын зээллэгийн зардлыг бууруулах,
 - **Өрийн зохицуулалтын цогц үйл ажиллагааг** оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх замаар Засгийн газрын өрийн **зохистой бүтцийг бий болгох**.

Өрийн удирдлагын талаар хууль эрх зүйн орчин


4. Өрийн удирдлагын асуудалд холбогдох журам, аргачлалууд

Өрийн удирдлагын асуудалд холбогдох **8 журам, аргачлалыг** шинээр батлуулан, хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

- Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээл;
- Засгийн газрын өрийн баталгаа ба өрийн баталгааны сан;
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах;
- Засгийн газрын өрийн үйлчилгээ;
- Өрийн мэдээллийн нэгдсэн сан ба тайлагналт;
- Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн барааг татвараас чөлөөлөх.

2. Улсын нийт гадаад өр болон Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал

Улсын нийт гадаад өр (2015 оны II улирал)




Тэмдэглэл:

Улсын нийт гадаад өрийн статистик тоон мэдээллийг Монголбанкнаас нэгтгэн хэвлэдэг ба Засгийн газрын гадаад өрөөс гадна Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн гадаад өрийг хамардаг илүү том хүрээний тоон мэдээлэл юм. Засгийн газрын өрд багтдаг Засгийн газрын баталгаа бүхий зээллэг нь Монголбанкны тайлангийн бусад салбарууд гэсэн ангилалд ордог тул давхардлыг хасч тооцсон.

Улсын нийт гадаад өр (2015 оны II улирал)

Улсын нийт гадаад өр



Улсын нийт гадаад өр 2015 оны II улирлын эцэст **21.7 тэрбум ам.доллар**ын үлдэгдэлтэй байгаагаас

- Засгийн газрын гадаад өр **5.0 тэрбум ам.доллар**,
- Төвбанкны гадаад өр **1.9 тэрбум ам.доллар**,
- Хадгаламжийн байгууллагуудын гадаад өр **2.1 тэрбум ам.доллар**,
- Компани хоорондын зээллэг **10.5 тэрбум ам.доллар** байна.

Засгийн газрын өр (2015 оны III улирал)


/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2014	2015-I	2015-II	2015-III
Засгийн газрын өр (1+2+3+4+5+6+7)				
1 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл	3,979.1	4,057.5	4,017.6	4,156.7
2 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл	2,964.1	3,004.3	3,196.5	3,161.8
3 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл	2,828.4	2,973.1	3,244.7	3,317.5
4 Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл	2,544.4	2,696.1	2,652.3	2,717.8
5 Татварын урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл	313.7	275.3	231.6	207.1
6 Төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл	0.0	0.0	310.3	321.6
7 Засгийн газрын дотоод зээлийн үлдэгдэл	0.0	0.0	30.0	30.0
Засгийн газрын өрийн үлдэгдэл				
Засгийн газрын өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	12,629.7	13,006.3	13,682.9	13,912.5
Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	3,277.8	3,279.6	3,768.4	3,720.6
Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	9,351.9	9,726.8	9,914.5	10,192.0
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦэнээр)	10,535.1	10,594.9	11,322.8	11,286.8
Хуулиар тогтоосон өрийн дээд хязгаар	-	58.3%	58.3%	58.3%
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ) / ДНБ	48.0%	44.2%	47.2%	47.9%


Засгийн газрын ӨҮЦ-ээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 2014 оны гүйцэтгэлээр **48.0 хувьд** хүрч, 2015 оны III улирлын байдлаар **47.9 хувьтай** байна.

Засгийн газрын өрийн бүтэц


Засгийн газрын өрийн бүтэц



Дотоод өрийн бүтэц




Гадаад өрийн бүтэц



- Засгийн газрын нийт өрийн багцын **26.7 хувийг** дотоод өр, **73.3 хувийг** гадаад өр эзэлж байна.
- Дотоод өрийн **85.0 хувийг** дотоод үнэт цаас эзэлж байна.
- Гадаад өрийн **40.8 хувийг** түнш орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээл, **59.2 хувийг** гадаад үнэт цаас болон баталгаа бүхий гадаад зээллэг эзэлж байна.

Төсвийг батлах явцад орсон өөрчлөлт (2010-2015 он)


ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд УИХ-ын хэлэлцүүлгийн
явцад оруулсан өөрчлөлт /тэрбум төгрөг/



Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсөвт 2011 он, 2012 онд хамгийн их өөрчлөлт орж УИХ-аас баталсан ба нэгдсэн төсвийн алдагдлыг 2011 онд **584.6 тэрбум төгрөг**, 2012 онд **257,1 тэрбум төгрөг**өөр тус тус нэмэгдүүлсэн.

Улсын төсвийн алдагдал (2011-2015 он)

Улсын төсвийн алдагдал vs ЗГҮЦ гаргалт



- Сүүлийн жилүүдэд улсын төсвийн алдагдал, улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх шаардлагын улмаас шинээр гаргах Засгийн газрын үнэт цаасны хэмжээ ихэссэн.
- ЗГ-ын дотоод үнэт цаасны үлдэгдлийг 2016 оны төсвийн жилээс эхлэн бууруулах чиглэл баримталж байна.

Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээ (баталгааг оруулсан)



Засгийн газрын нийт гадаад өрийн эргэн төлөлтийн хувьд 2017 онд **580.0 сая ам.доллар**, 2018 онд **661.2 сая ам.доллар**ын томоохон төлбөрүүд төлөгдөнө.


Гадаад өрийн үйлчилгээг гүйцэтгэхэд тулгарч буй хүндрэлүүд

Дээр дурдсан их хэмжээний гадаад төлбөрийг гүйцэтгэхэд дараах хүндрэлүүд үүсэхээр байна. Үүнд:

- Төсвөөс хуримтлал үүсгэн төлөх боломжгүй,
- Гадаад зээллэг хийх, эсхүл гадаадын шууд хөрөнгө оруулалтыг огцом нэмэгдүүлээгүй тохиолдолд гадаад валютын нөөцийг шавхаж, үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал алдагдана,
- Эргэн төлөлтийн хугацаа ойртох тусам дахин санхүүжилтийн зардал нэмэгдэж, зохицуулалтын арга хэмжээ авах боломж багасна.

Дүгнэвэл, дунд хугацаанд Засгийн газрын гадаад өрийн төлбөрийг **дотоод эх үүсвэрээр гүйцэтгэх боломжгүй** бөгөөд өрийг **дахин санхүүжүүлэх, хугацааг сунгах** арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж эхлэх шаардлагатай.

Өрийн зохицуулалтын арга хэмжээ авсны дараах Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээ



- ЗГ-ын гадаад өрийн оновчтой бодлого, зохицуулалтын арга хэмжээ авснаар төсөвт ирэх ачааллыг жигдлэх, гадаад валютын нөөцөд огцом өөрчлөлтгүй, эдийн засаг тогтвортой байх ач холбогдолтой.
- Урт хугацаанд төлөгдөх төлбөрийг хуримтлалын сан “**Sinking fund**” байгуулах замаар төсвөөс хуримтлал үүсгэн төлөх бүрэн боломжтой.

3. Дунд хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрийн удирдлагын бодлого, зохицуулалт

Дунд хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрийн удирдлагын бодлого, зохицуулалт

Дунд хугацаанд Засгийн газрын зүгээс өрийн удирдлагын чиглэлээр дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Гадаад валютын огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр 2017, 2018 оны томоохон төлбөрүүдийн төсөвт ирэх өрийн үйлчилгээний ачааллыг жигдэлж, өрийн **дахин санхүүжилтийн арга хэмжээ** авах;
2. Олон улсын зах зээлд тогтмол үйл ажиллагаа явуулах замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг сайжруулах, **зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх**, дахин санхүүжилтийн зардлыг бууруулах;
3. Зах зээлийн эрэлтэд нийцүүлж зохистой хэмжээгээр гаргах замаар Засгийн газрын **дотоод үнэт цаасны үлдэгдэл болон хүүгийн түвшинг бууруулах** чиглэл баримтлах;
4. Дотоод үнэт цаасны давуу тал, ач холбогдлыг сурталчлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, **хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх**, арилжааны идэвхийг сайжруулах.

Засгийн газрын өр (2015-2016)

2015, 2016 оны төсвийн төсөлд туссан гадаад зээлийн ашиглалт, Засгийн газрын үнэт цаас болон өрийн баталгаа гаргалт, тэдгээрийн эргэн төлөлт, холбогдох өрийн зохицуулалтын арга хэмжээг оруулснаар өрийн тухай төсвийн тусгай шаардлага дараах байдалтай болохоор байна.

			/тэрбум төгрөг/	
ҮЗҮҮЛЭЛТҮҮД			2015	2016
Засгийн газрын өр (1+2+3+4+5+6+7)				
1	Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл		4,711.4	5,255.0
2	Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл		3,061.7	3,076.3
3	Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл		4,642.8	4,864.6
4	Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл		2,774.9	3,220.3
5	Татварын урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл		153.0	51.6
6	Төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл		225.3	661.4
7	Засгийн газрын дотоод зээлийн үлдэгдэл		0.0	0.0
Засгийн газрын өрийн үлдэгдэл				
	Засгийн газрын өрийн үлдэгдэл (нэрлэсэн)		15,569.1	17,129.1
	Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦэнээр)		13,672.5	15,015.1
	Хуулиар тогтоосон өрийн дээд хязгаар		58.3%	55.0%
	Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ) / ДНБ		58.0%	54.4%



САНГИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

